ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2024/054/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.......................................................................................... 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.............................................5-9

3. Аудитын илрүүлэлт ...................................................................................................14

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..........................................................15

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| АЗДТГ | Аймгийн Засаг даргын Тамгын газар |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг 21000
ЗДТГ-ын II байр, утас/факс: 7058-4203

2025.02.24 № 265

танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА Ч.ОЮУНАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудал

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилго, 15 зорилтын хүрээнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 91.8 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

011022100

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **813,921,172.07** | **299,883,348.38** |
| **33** | **АВЛАГА** | 127,862,000.00 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 127,862,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 686,059,172.07 | 299,883,348.38 |
| **351** | **Түүхий эд материал** | 659,548,654.03 | 279,460,279.34 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 48,220,606.81 | 25,208,768.47 |
| 35130 | Эм боох материал | 611,328,047.22 | 254,251,510.87 |
| **354** | **Хангамжийн материал** | 26,510,518.04 | 20,423,069.04 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 855,099.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 14,335,215.00 | 9,102,865.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,981,404.04 | 1,981,404.04 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,338,800.00 | 9,338,800.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,329,191,419.89** | **3,327,570,962.22** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,329,191,419.89 | 3,327,570,962.22 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,227,341,419.89 | 3,225,720,962.22 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,232,954,285.00 | 2,375,639,488.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (47,378,425.93) | (98,114,994.79) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 349,379,988.00 | 349,379,988.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (141,354,141.00) | (177,025,473.24) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,071,622,809.98 | 1,215,550,071.69 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (305,818,344.03) | (486,360,873.47) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 129,406,748.70 | 129,406,748.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (72,398,283.99) | (84,790,211.36) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 309,547,636.00 | 309,547,636.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (298,620,852.84) | (307,511,417.31) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 101,850,000.00 | 101,850,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,520,000.00 | 1,520,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,520,000.00) | (1,520,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 101,850,000.00 | 101,850,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,143,112,591.96** | **3,627,454,310.60** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,143,112,591.96** | **3,627,454,310.60** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,143,112,591.96 | 3,627,454,310.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 644,255,978.44 | 644,255,978.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 542,405,978.44 | 542,405,978.44 |
| 51102 | - хувийн | 101,850,000.00 | 101,850,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,498,856,613.52 | 2,983,198,332.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,498,856,613.52 | 3,498,856,613.52 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (515,658,281.36) |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,143,112,591.96** | **3,627,454,310.60** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,400,219,181.33** | **5,382,789,991.57** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,034,379,333.33** | **1,325,891,780.57** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,034,379,333.33 | 1,325,891,780.57 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,365,839,848.00** | **4,056,898,211.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,520,785,994.00 | 3,240,669,913.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,520,785,994.00 | 3,240,669,913.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 845,053,854.00 | 816,228,298.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, | 67,158,498.00 | 38,228,280.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 585,364,381.00 | 720,115,318.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 192,530,975.00 | 55,439,700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 2,445,000.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,715,980,975.87** | **5,594,944,848.61** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,715,980,975.87** | **5,594,944,848.61** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,320,150,737.32 | 3,642,219,115.76 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 930,171,500.00 | 1,032,510,900.07 |
| 210101 | Үндсэн цалин | 532,214,854.66 | 613,818,880.50 |
| 210102 | Нэмэгдэл | 257,664,478.59 | 293,264,765.26 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 58,821,356.13 | 43,451,760.50 |
| 210104 | Урамшуулал | 81,470,810.62 | 81,975,493.81 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 99,013,528.09 | 128,633,061.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,863,628.09 | 87,466,863.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,287,600.00 | 10,722,423.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,430,100.00 | 5,662,044.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,856,900.00 | 5,312,429.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,575,300.00 | 19,469,300.23 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,282,718.46 | 31,563,326.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,360,271.75 | 7,760,052.31 |
| 210302 | Түлш, халаалт | 16,139,800.00 | 14,809,949.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,782,646.71 | 8,993,324.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 77,657,698.70 | 69,359,267.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,745,910.00 | 6,282,099.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,383,520.00 | 56,042,175.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,819,541.14 | 988,722.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 381,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 33,708,727.56 | 5,664,571.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 1,233,415,585.70 | 1,120,070,281.66 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,216,570,245.70 | 1,109,345,471.66 |
| 210502 | Хоол, хүнс | 16,765,340.00 | 10,378,810.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 80,000.00 | 346,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,428,688.20 | 47,552,002.04 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,387,423.20 | 38,212,952.04 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 164,050.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,877,215.00 | 9,339,050.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 39,314,700.00 | 56,196,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 39,314,700.00 | 56,196,800.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,949,616.00 | 8,755,674.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,360,000.00 | 1,600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,052,700.00 | 1,032,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 292,112.00 | 225,712.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,358,190.00 | 5,115,162.00 |
| 210807 | Газрын төлбөр | 754,614.00 | 650,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 878,916,702.17 | 1,147,577,803.14 |
| 210901 | Бараа үйтчилгээний бусад зардал | 639,532,082.00 | 850,988,675.23 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,020,160.00 | 953,554.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 232,364,460.17 | 295,635,573.91 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,395,830,238.55 | 1,952,725,732.85 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,359,839,749.50 | 1,688,243,613.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 820,716,727.50 | 759,565,213.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 539,123,022.00 | 925,528,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 3,150,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 29,590,489.05 | 264,482,119.85 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,590,489.05 | 264,482,119.85 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,400,000.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,400,000.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-315,761,794.54** | **-212,154,857.04** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 139,321,906.59 | 303,503,424.32 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 139,321,906.59 | 303,503,424.32 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -139,321,906.59 | -303,503,424.32 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-455,083,701.13** | **-515,658,281.36** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,365,839,848.24** | **4,184,760,211.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,365,839,848.00** | **4,184,760,211.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,520,785,994.00 | 3,240,669,913.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,520,785,994.00 | 3,240,669,913.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 845,053,854.00 | 944,090,298.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 67,158,498.00 | 38,228,280.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 585,364,381.00 | 720,115,318.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 192,530,975.00 | 55,439,700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 130,307,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,363,339,848.24** | **4,184,760,211.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,363,339,848.24** | **4,184,760,211.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,839,647,609.69** | **2,232,034,478.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 930,171,500.00 | 1,039,147,148.05 |
| 210101 | Үндсэн цалин | 532,214,854.66 | 620,455,128.48 |
| 210102 | Нэмэгдэл | 257,664,478.59 | 293,264,765.26 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 58,821,356.13 | 43,451,760.50 |
| 210104 | Урамшуулал | 81,470,810.62 | 81,975,493.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 99,013,528.09 | 128,633,061.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,863,628.09 | 87,466,863.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,287,600.00 | 10,722,423.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,430,100.00 | 5,662,044.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,856,900.00 | 5,312,429.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,575,300.00 | 19,469,300.23 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,282,718.46 | 31,563,326.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,044,173.75 | 7,760,052.31 |
| 210302 | Түлш, халаалт | 16,139,800.00 | 14,809,949.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,098,744.71 | 8,993,324.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,965,357.34 | 50,907,768.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,024,385.00 | 8,800,440.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,077,080.00 | 38,242,695.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,682,990.34 | 988,722.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 736,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,180,902.00 | 2,139,211.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 22,397,182.00 | 13,858,897.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,934,182.00 | 253,947.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,383,000.00 | 13,383,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 80,000.00 | 221,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,809,400.00 | 32,348,349.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,138,000.00 | 24,939,049.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 164,050.00 | 124,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,507,350.00 | 7,284,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 39,314,700.00 | 56,196,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 39,314,700.00 | 56,196,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,086,166.80 | 8,755,674.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,360,000.00 | 1,600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,052,700.00 | 1,032,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 292,112.00 | 225,712.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,494,740.80 | 5,115,162.00 |
| 210807 | Газрын төлбөр | 754,614.00 | 650,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 660,607,057.00 | 870,623,454.25 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 653,318,357.00 | 869,669,900.25 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,288,700.00 | 953,554.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,523,692,238.55** | **1,952,725,732.85** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,359,839,749.50 | 1,688,243,613.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 820,716,727.50 | 759,565,213.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 539,123,022.00 | 925,528,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 3,150,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 157,452,489.05 | 264,482,119.85 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 157,452,489.05 | 264,482,119.85 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,400,000.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,400,000.00 | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 560,705,978.44 | - | 3,953,940,314.65 | 4,514,646,293.09 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 560,705,978.44 | - | 3,953,940,314.65 | 4,514,646,293.09 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (455,083,701.13) | (455,083,701.13) |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 644,255,978.44 | - | 3,498,856,613.52 | 4,143,112,591.96 |
| D01 | 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 644,255,978.44 | - | 3,498,856,613.52 | 4,143,112,591.96 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 644,255,978.44 | - | 3,498,856,613.52 | 4,143,112,591.96 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (515,658,281.36) | (515,658,281.36) |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 644,255,978.44 | - | 2,983,198,332.16 | 3,627,454,310.60 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,385,462,100.00 | 2,979,092,853.15 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,385,462,100.00 | 2,979,092,853.15 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,366,493,900.00 | 1,290,849,240.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,070,571,700.00 | 1,010,767,069.05 |
| 210101 | Үндсэн цалин | 645,002,600.00 | 620,455,128.48 |
| 210102 | Нэмэгдэл | 267,578,600.00 | 264,884,686.26 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 65,523,000.00 | 43,451,760.50 |
| 210104 | Урамшуулал | 92,467,500.00 | 81,975,493.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 134,396,200.00 | 125,085,550.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,421,600.00 | 85,054,557.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,743,600.00 | 10,438,622.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,871,800.00 | 5,520,144.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,871,800.00 | 5,170,529.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,487,400.00 | 18,901,696.23 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,381,000.00 | 31,563,326.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,215,700.00 | 7,760,052.31 |
| 210302 | Түлш, халаалт | 15,392,500.00 | 14,809,949.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,772,800.00 | 8,993,324.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 41,492,800.00 | 41,480,633.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,764,000.00 | 4,756,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,862,800.00 | 32,860,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 988,800.00 | 988,722.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 736,700.00 | 736,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,140,500.00 | 2,139,211.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 505,800.00 | 475,347.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 284,200.00 | 253,947.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 221,600.00 | 221,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 32,385,300.00 | 32,348,349.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,972,000.00 | 24,939,049.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 124,600.00 | 124,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,288,700.00 | 7,284,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 23,067,800.00 | 23,067,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 23,067,800.00 | 23,067,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,025,900.00 | 8,755,674.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,713,000.00 | 1,600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,032,700.00 | 1,032,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 302,400.00 | 225,712.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,119,500.00 | 5,115,162.00 |
| 210807 | Газрын төлбөр | 748,300.00 | 650,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21667400.00 | 17,305,491.25 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,712,800.00 | 16,351,937.25 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 954,600.00 | 953,554.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2018968200.00 | 1,688,243,613.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,018,968,200.00 | 1,688,243,613.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,090,281,000.00 | 759,565,213.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 925,528,400.00 | 925,528,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,158,800.00 | 3,150,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,385,462,100.00 | 2,979,092,853.15 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,385,462,100.00 | 2,979,092,853.15 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,385,462,100.00 | 2,979,092,853.15 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 46 | 34 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 38 | 26 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7 | 7 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **46** | **36** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 19 | 15 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 15 | 12 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 12 | 7 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **845,053,854.00** | **941,185,238.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **706,560,395.00** | **941,185,238.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 706,560,395.00 | 941,185,238.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 28,380,079.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 28,380,079.00 |
| 210104 | Урамшуулал | 4,407,000.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 3,547,511.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 2,412,306.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 283,801.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 141,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 141,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 567,604.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,150,480.00 | 9,427,135.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,260,400.00 | 4,044,440.00 |
| 210402 | Түлш, шатахуун | 3,215,080.00 | 5,382,695.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 675,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 20,383,000.00 | 13,383,550.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,383,000.00 | 13,383,550.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,077,450.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,077,450.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 21,904,000.00 | 33,129,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,904,000.00 | 33,129,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,360,000.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,360,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 647,278,465.00 | 853,317,963.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 640,962,865.00 | 853,317,963.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,315,600.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 138,493,459.00 | - |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 138,493,459.00 | - |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 845,053,854.00 | 941,185,328.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 845,053,854.00 | 941,185,328.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 38,228,280.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 585,364,381.00 | 718,710,258.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 259,689,473.00 | 55,439,700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 128,807,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,247.0 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрснээс, 935.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 11,312.0 сая төгрөгийн 1 албан шаардлага өгч ажиллалаа.

### 3.1 Төлбөрийн акт

Албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулан 935.0 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 Албан шаардлага

Газрын дарга, ахлах нягтлан бодогч, эдийн засагч, хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, санхүүгийн ажилтан нарт 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 11,312.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

***Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| *Зөрчлийн товч утга* | *Нийт зөрчил* | | *Үүнээс* | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | *Төлбөрийн акт* | | *Албан шаардлага* | | *Зөвлөмж* | | *Хариуцлага тооцуулах албан шаардлага* | | *Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал* | |
| | *Тоо* | *Дүн* | *Тоо* | *Дүн* | *Тоо* | *Дүн* | *Тоо* | *Дүн* | *Тоо* | *Албан тушаалтны тоо* | *Тоо* | *Дүн* |
| хоол, унааны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулан *олгосон* | *1* | *935.0* | *1* | *935.0* | -- | - | - | - | - | - | - | - |
| мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон | *1* | *11,312.0* | - | | *1* | *11,312.0* | - | -- | | -- | - | - |
| ***Дүн*** | **2** | ***12,247.0*** | **1** | **935.0** | **1** | ***11,312.0*** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр  Дугаар 11/А1160305  Чойбалсан хот
ДОА-2025/054/НА-СТА-ТӨ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулан 935.0 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан тооцож олгосон 935,000.00 /Есөн зуун гучин таван мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа, нягтлан бодогч Б.Батцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ

2125050026

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр Дугаар 22/A1160305 Чойбалсан хот

ДОА-2025/054/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын дарга, ахлах нягтлан бодогч, эдийн засагч, хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, санхүүгийн ажилтан нарт 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 11,312.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх *”хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа, нягтлан бодогч Б.Батцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА
АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041533